

ТӨРИЙН НУУЦЫН ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсад 1995 онд Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль батлагдсанаар төрийн нууцыг хамгаалахтай холбогдсон харилцааг анх удаа хуулиар зохицуулж, төрийн нууцыг хамгаалах тогтолцоо, эрх зүйн үндсийг тавьсан.

Улмаар 2016 оны 12 дугаар сард Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийг тус тус хүчингүй болгож, Төрийн болон албаны нууцын тухай хуулийг баталсан байна.

Төрийн болон албаны нууцын тухай хууль урьд хүчин төгөлдөр үйлчилж байсан Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиас ялгагдах зарчмын шинжтэй харилцаа нь албаны нууц гэх ойлголтыг оруулж ирсэн, түүнчлэн Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг хуулиар бус Засгийн газрын тогтоолоор баталж байхаар өөрчлөлт орсон.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17 дахь хэсэгт "...улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр...-ийн нууцыг хуулиар тогтоон хамгаална..." хэмээн заасан. Ардчилсан нийгэмд төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр үйл ажиллагаа олон нийтэд аль болох ил тод, нээлттэй, энэ талаарх мэдээлэл хүртээмжтэй байх ёстой. Хэдий тийм ч нийтийн ашиг сонирхол буюу "улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах" зорилгоор тодорхой мэдээллийг зөвхөн хуулиар тогтоох замаар иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хязгаарлаж болохоор Үндсэн хуульд заасан.

Гэвч Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг хуулиар бус Засгийн газрын тогтоолоор баталдаг болсон нь хэлбэрийн хувьд Үндсэн хуульд нийцэхгүй байгаагаас гадна мэдээллийг төрийн нууцад хамааруулах шалгуур, босго "намсаж", үүнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын хяналт байхгүй болсон. Үүний улмаас Засгийн газар нь мэдээллийг төрийн нууцад авахдаа Улсын Их Хурлын хяналтгүйгээр дур зоргоор шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн. Мөн түүнчлэн үүнийг дагаад иргэдийн мэдээлэл хайх хүлээн авах эрх хумигдаж, хууль бус үйлдлүүдээ Засгийн газар өөрөө мэдэн нууцлах эрх зүйн үндэс бий болсон.

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн дагуу төрийн нууцад хамааруулж байсан мэдээлэл 60 орчим байсан бол Засгийн газрын тогтоолоор төрийн нууцад авсан мэдээллийн тоо давхцалгүй тоогоор 400 гаран болж даруй 7 дахин нэмэгдсэн. Үүнээс гадна "албаны нууц" гэх ойлголтын хүрээнд төрийн байгууллага нь "төрийн байгууллагын нууц" гэсэн ойлголтыг дотооддоо бүрдүүлэх болсон. Тодруулбал төрийн байгууллагууд өөрийн байгууллага тус бүрдээ мэдээллийг нууцалдаг болсон нь нууцын талаарх ойлголтыг хавтгайруулж, иргэдийн мэдээллийн авах эрхийг боогдуулж, нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль тогтоомжийн

хэрэгжилтэд саад учирч эхэлсэн. Тиймээс хуулийн төслөөр дараах хоёр зарчмын асуудлыг шийдвэрлэхээр тусгасан. Үүнд:

- Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг Засгийн газар бус Улсын Их Хурал баталдаг байх;
- албаны нууц гэсэн ойлголтыг халах.

Дээр дурдсан өөрчлөлт нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 50 хувиас илүү заалтыг хөндөж байгаа тул Монгол Улсын Засгийн газраас өгсөн саналыг хүлээн авч хуульд нэмэлт өөрчлөлт, оруулах хуулийн төсөл хэлбэртэй байсныг шинэ найруулга хэлбэрт оруулан өөрчилсөн.

Хуулийн төслийн Улсын Их Хурлын d.parliament.mn цахим хуудаст 2025 оны 12 дугаар сарын 12-ны байршуулсан ба тусгайлан санал ирээгүй болно.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ

ТӨРИЙН НУУЦЫН ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙН ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсад 1995 онд Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль батлагдсанаар төрийн нууцыг хамгаалахтай холбогдсон харилцааг анх удаа хуулиар зохицуулж, төрийн нууцыг хамгаалах тогтолцоо, эрх зүйн үндсийг тавьсан.

Улмаар 2016 оны 12 дугаар сард Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийг тус тус хүчингүй болгож тухайн харилцааг зохицуулж байсан харилцааг зохицуулах зорилгоор Төрийн болон албаны нууцын тухай хуулийг баталсан байна.

Төрийн болон албаны нууцын тухай хууль урьд хүчин төгөлдөр үйлчилж байсан Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиас ялгагдах зарчмын шинжтэй харилцаа нь албаны нууц гэх ойлголтыг оруулж ирсэн, түүнчлэн Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг хуулиар бус Засгийн газрын тогтоолоор баталж байхаар өөрчлөлт орсон.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17 дахь хэсэгт “...улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр...-ийн нууцыг хуулиар тогтоон хамгаална...” хэмээн заасан. Ардчилсан нийгэмд төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр үйл ажиллагаа олон нийтэд аль болох ил тод, нээлттэй, энэ талаарх мэдээлэл хүртээмжтэй байх ёстой. Хэдий тийм ч нийтийн ашиг сонирхол буюу “улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах” зорилгоор тодорхой мэдээллийг зөвхөн хуулиар тогтоох замаар иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хязгаарлаж болохоор Үндсэн хуульд заасан.

Гэвч Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг хуулиар бус Засгийн газрын тогтоолоор баталдаг болсон нь хэлбэрийн хувьд Үндсэн хуульд нийцэхгүй байгаагаас гадна мэдээллийг төрийн нууцад хамааруулах шалгуур, босго “намсаж”, үүнтэй холбоотойгоор Улсын Их Хурлын хяналт байхгүй болсон. Сөрөг үр дагаварт нь гүйцэтгэх эрх мэдлийн байгууллага болох Засгийн газар нь мэдээллийг төрийн нууцад авахдаа Улсын Их Хурлын хяналтгүйгээр дур зоргоор шийдвэрлэх боломжийг бүрдүүлсэн. Мөн түүнчлэн үүнийг дагаад иргэдийн мэдээлэл хайх хүлээн авах эрх хумигдаж, хууль бус үйлдлүүдээ Засгийн газар өөрөө мэдэн нууцлах эрх зүйн үндэс бий болсон.

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн дагуу төрийн нууцад хамааруулж байсан мэдээлэл 60 орчим байсан бол Засгийн газрын тогтоолоор төрийн нууцад авсан мэдээллийн тоо давхцалгүй тоогоор 400 гаран болж даруй 7 дахин нэмэгдсэн.

Үүнээс гадна “албаны нууц” гэх ойлголтын хүрээнд төрийн байгууллага нь “төрийн байгууллагын нууц” гэсэн ойлголтыг дотооддоо бүрдүүлэх болсон. Тодруулбал төрийн байгууллагууд өөрийн байгууллага тус бүрдээ мэдээллийг

нууцалдаг болсон нь нууцын талаарх ойлголтыг хавтгайруулж, иргэдийн мэдээллийн авах эрхийг боогдуулж, нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд саад учирч эхэлсэн. Тиймээс хуулийн төслөөр дараах хоёр зарчмын асуудлыг шийдвэрлэхээр тусгасан. Үүнд:

- Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг Засгийн газар бус Улсын Их Хурал баталдаг байх;
- Албаны нууцыг халах.

Өөрөөр хэлбэл хуулийн төсөл нь Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан “албаны нууц” гэх ойлголтыг хуулиас хасахаар үзэл баримтлалын хүрээнд боловсруулагдсан. Уг өөрчлөлт нь хуулийн төсөл нь эх хуулийн тавиас дээш хувийн заалтыг хамарч байгаа тохиолдолд Хууль тогтоомжийн тухай хуульд заасан ерөнхий шаардлагын дагуу “шинэчилсэн найруулга” хэлбэрээр боловсруулах шаардлагатай гэсэн Засгийн газраас өгсөн саналын дагуу хуулийн төслийн “шинэчилсэн найруулга” хэлбэрээр боловсруулагдав. Үүнд:

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Хуулийн төслийн нэгдүгээр бүлэгт төрийн нууцыг хамгаалахтай холбоотой эрх зүйн зохицуулалтын үндэс, хуулийн зорилт, үйлчлэх хүрээ, мэдээллийг төрийн нууцад хамааруулах зарчим, нэр томъёоны тодорхойлолт болон төрийн нууцыг хамгаалах нийтлэг үүргийг тодорхойлсон.

Хуулийн төслийн зорилт нь Монгол Улсын төрийн нууцыг хамгаалах үндэсний тогтолцоо, эрх зүйн үндсийг тодорхойлох, төрийн нууцад хамаарах мэдээллийг нууцлах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино. Төрийн нууцын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, энэхүү хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжийн актаас бүрдэхээр тусгасан.

Мөн энэхүү хууль нь Монгол Улсын төрийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтан, иргэн дагаж мөрдөх бөгөөд Монгол Улсын төрийн нууцтай танилцсан гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн мөн адил энэ хуулийг биелүүлэх үүрэгтэй байхаар зохицуулсан. Гадаад улс болон олон улсын байгууллагаас шилжүүлэн өгсөн төрийн нууцад хамаарах мэдээллийг хамгаалахад мөн адил энэ хуульд заасан журмыг баримтлахаар тусгасан.

Түүнчлэн мэдээллийг төрийн нууцад хамааруулах, нууцлахад хуульд нийцсэн, үндэслэлтэй, цаг үеэ олсон байх зарчмыг баримтлах бөгөөд төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг хуулиар батлах зохицуулалтыг тусгасан. Хууль зөрчсөн үйлдэл, авлига, ашиг сонирхлын зөрчил, хүний үндсэн эрх, эрх чөлөөг зөрчсөн баримт зэрэг мэдээллийг төрийн нууцад хамааруулахыг хориглохоор тусгайлан заасан.

Мөн “төрийн нууц”, “төрийн нууц тээгч”, “мэдээллийг нууцлах”, “нууцын зэрэглэл”, “төрийн нууцтай танилцах эрх”, “төрийн нууцыг хамгаалах”, “төрийн нууцыг

задруулах”, “төрийн нууцыг үрэгдүүлэх” зэрэг ойлголтын тодорхойлолтыг хуульд тусган, ойлголтын нэгдмэл байдлыг хангах зохицуулалтыг тусгасан.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. ТӨРИЙН НУУЦЫГ ХАМГААЛАХ ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ БҮРЭН ЭРХ

Хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт төрийн нууцыг хамгаалах талаар төрийн байгууллага, албан тушаалтны хэрэгжүүлэх бүрэн эрхийг тодорхойлсон.

Улсын Их Хурал нь төрийн нууцыг хамгаалах талаар төрийн бодлого, хууль тогтоомжийг батлах, хэрэгжилтэд хяналт тавих, төрийн нууцыг хамгаалах чиглэлээр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, үйл ажиллагаанд шаардлагатай хөрөнгийг улсын төсөвт тусгаж батлах бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр тусгасан.

Монгол Улсын Ерөнхийлөгч нь Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүний хувьд төрийн нууцын хамгаалалтад хяналт тавих, холбогдох төрийн байгууллагын тайлан, мэдээллийг сонсох, Засгийн газарт чиглэл өгөх бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр заасан.

Засгийн газар нь улсын хэмжээнд төрийн нууцыг хамгаалах үйл ажиллагааг уялдуулан зохицуулах бөгөөд төрийн нууцын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, төрийн нууцыг хамгаалах бодлого, хөтөлбөр, эрх зүйн баримт бичгийг боловсруулах, холбогдох дүрэм журам батлах, төрийн нууцыг харилцан солилцох, хамгаалах асуудлаар олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр тусгасан.

Мөн байгууллага, албан тушаалтнууд өөрийн эрхэлсэн салбар, харьяа байгууллагын хэмжээнд төрийн нууцыг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төрийн нууцын хамгаалалтад хяналт тавих, шаардлагатай арга хэмжээ авах үүрэгтэй байхаар тусгасан.

Тагнуулын байгууллага нь төрийн нууцыг хамгаалах чиглэлээр төрийн нууц задрахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, төрийн нууцын хамгаалалтын байдалд хяналт шалгалт хийх, төрийн нууцыг хамгаалах техник, криптографийн хэрэгслийг баталгаажуулах, төрийн нууцын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулах, төрийн нууцтай танилцах иргэн, албан тушаалтанд аюулгүй байдлын шалгалт явуулах зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр зохицуулсан.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТӨРИЙН НУУЦАД ХАМААРУУЛАХ МЭДЭЭЛЭЛ

Хуулийн төслийн гуравдугаар бүлэгт төрийн нууцад хамааруулах мэдээллийн төрөл, хүрээг тодорхойлон тогтоосон.

Төрийн нууцад хамаарах мэдээллийг төрийн бодлого, эдийн засаг, шинжлэх ухаан, технологи, батлан хамгаалах, тагнуул, сөрөх тагнуул, хууль сахиулах үйл ажиллагаа, мэдээллийн аюулгүй байдал болон бусад холбогдох салбарын хүрээнд ангилан тодорхойлсон.

Тухайлбал, Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын үзэл баримтлалын нууцалбал зохих хэсэг, гадаад улс оронтой харилцах бодлогын нарийвчилсан мэдээлэл, батлан хамгаалах бодлого, зэвсэгт хүчний зохион байгуулалт, байлдааны бэлэн байдлын тухай мэдээлэл, улсын дайчилгааны төлөвлөгөө, улсын болон батлан хамгаалах нөөцийн бодит хэмжээ, байршил зэрэг мэдээллийг төрийн нууцад хамааруулахаар тусгасан.

Мөн тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын үйл ажиллагаа, мэдээллийн эх сурвалж, нууц ажилтантай холбоотой мэдээлэл, гүйцэтгэх ажиллагааны арга тактик, техник хэрэгсэл, түүнчлэн төрийн шифр харилцаа, тусгай холбооны сүлжээ, төрийн тусгай хамгаалалтын зохион байгуулалт зэрэг мэдээллийг төрийн нууцад хамааруулах зохицуулалтыг тусгасан.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. МЭДЭЭЛЛИЙГ НУУЦЛАХ БОЛОН ИЛ БОЛГОХ

Хуулийн төслийн дөрөвдүгээр бүлэгт төрийн нууцад хамаарах мэдээллийг нууцлах, нууцын зэрэглэл тогтоох, нууцлах хугацаа тогтоох, мөн нууцыг ил болгохтой холбогдсон харилцааг зохицуулсан.

Төрийн нууцад хамаарах мэдээллийг задруулах, үрэгдүүлэх тохиолдолд учирч болох хохирлын хэмжээнээс хамааран “онц чухал нууц”, “маш нууц”, “нууц” гэсэн гурван зэрэглэлд ангилахаар заасан.

Мөн төрийн нууцад хамаарах мэдээллийг “онц чухал нууц” зэрэглэлтэй бол 30 жил, “маш нууц” зэрэглэлтэй бол 20 жил, “нууц” зэрэглэлтэй бол 10 жил нууцлахаар тусгасан. Зарим төрлийн мэдээллийг тухайлбал тагнуулын байгууллагын нууц ажилтан, нууцаар хамтран ажиллагчтай холбоотой мэдээллийг байнга нууцлахаар зохицуулсан.

Түүнчлэн нууцын зэрэглэл бүхий мэдээлэлд зохих тэмдэглэгээ тавих, бүртгэл хөтлөх, нууцлах хугацаа дууссан болон нууцлах шаардлага арилсан тохиолдолд мэдээллийг ил болгох журмыг тодорхойлсон.

ТАВДУГААР БҮЛЭГ. ТӨРИЙН НУУЦТАЙ ТАНИЛЦАХ

Хуулийн төслийн тавдугаар бүлэгт төрийн нууцтай танилцах нөхцөл, эрх олгох журам, нууцтай танилцах эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох үндэслэл, албан тушаалтан, иргэний үүргийг тодорхойлсон.

Төрийн нууцтай танилцах шаардлагатай албан тушаалтан, иргэн нь аюулгүй байдлын шалгалтад хамрагдаж, төрийн нууцыг задруулахгүй байх баталгааг бичгээр гаргасны үндсэн дээр тодорхой зэрэглэлийн нууцтай танилцах эрх олгогдохоор тусгасан.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд зэрэг албан тушаалтнууд төрийн нууцтай зэрэглэл харгалзахгүй танилцах эрхтэй байхаар заасан.

Түүнчлэн аюулгүй байдлын шалгалтад тэнцээгүй, худал мэдээлэл өгсөн, төрийн нууц хамгаалах журмыг удаа дараа зөрчсөн, гэмт хэрэгт холбогдсон зэрэг тохиолдолд төрийн нууцтай танилцах эрх олгохоос татгалзах, эсхүл олгосон эрхийг хүчингүй болгох зохицуулалтыг тусгасан.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ. ТӨРИЙН НУУЦЫГ ХАМГААЛАХ

Хуулийн төслийн зургаадугаар бүлэгт төрийн нууцыг хамгаалах үйл ажиллагааны зохион байгуулалт, нууцын хамгаалалтын техник, криптографын арга хэмжээ, төрийн нууцыг ашиглах, дамжуулах, хадгалах, устгах зэрэг үйл ажиллагааг зохицуулсан.

Төрийн нууцыг хамгаалах үйл ажиллагааг Засгийн газар улсын хэмжээнд уялдуулан зохицуулах бөгөөд тагнуулын байгууллага энэ чиглэлээр хяналт тавих, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлэхээр тусгасан.

Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд өөрийн байгууллагад төрийн нууцыг хамгаалах нэгж, эсхүл ажилтантай байх бөгөөд төрийн нууцтай холбоотой баримт бичиг, мэдээллийг боловсруулах, хадгалах, ашиглах, дамжуулах, бүртгэх, устгах зэрэг үйл ажиллагааг хууль болон холбогдох журмын дагуу хэрэгжүүлэхээр заасан.

Мөн төрийн нууцыг хамгаалах техник, криптографын хэрэгслийг ашиглах, баталгаажуулах, төрийн шифр харилцааны ажиллагааг зохион байгуулахтай холбоотой зохицуулалтыг тусгасан.

ДОЛДУГААР БҮЛЭГ. БУСАД ЗҮЙЛ

Хуулийн төслийн долдугаар бүлэгт төрийн нууцын тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын зохицуулалтыг тусгасан.

Төрийн нууцын тухай хууль тогтоомжийг зөрчсөн этгээдэд эрүүгийн, зөрчлийн болон сахилгын хариуцлага хүлээлгэхээр заасан бөгөөд төрийн нууцыг хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлээгүй албан тушаалтанд холбогдох сахилгын арга хэмжээ авах боломжийг тусгасан.

Мөн тагнуулын байгууллага төрийн нууцын хамгаалалттай холбоотой зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох байгууллага, албан тушаалтанд хариуцлага хүлээлгүүлэх талаар санал гаргах, шаардлага тавих эрхтэй байхаар зохицуулсан.

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн дараах зохицуулалтад туссан “албаны нууц” гэх ойлголтыг халахаар төсөлд тусгасан болно. Үүнд:

- Төрийн болон албаны нууцын тухай хуулийн гарчиг,

- Хоёрдугаар бүлгийн гарчиг,
- Гуравдугаар бүлгийн гарчиг,
- Тавдугаар бүлгийн гарчиг,
- Зургаадугаар бүлгийн гарчиг,
- 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэг,
- 2 дугаар зүйлийн гарчиг,
- 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэг,
- 3 дугаар зүйлийн 3.2, 3.3 дахь хэсэг,
- 4 дүгээр зүйлийн гарчиг,
- 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг,
- 5 дугаар зүйлийн 5.1.3-5.1.12 дахь заалт,
- 6 дугаар зүйлийн гарчиг,
- 6 дугаар зүйлийн 6.1-6.5 дахь хэсэг,
- 7 дугаар зүйлийн гарчиг,
- 7 дугаар зүйлийн 7.1, 7.2 дахь хэсэг,
- 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг, 8.1.1, 8.1.2 дахь заалт,
- 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг,
- 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, 10.1.1-10.1.5 дахь заалт,
- 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 11.1.1-11.1.4 дэх заалт,
- 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 12.1.1-12.1.11 дэх заалт,
- 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсэг,
- 16 дугаар зүйлийн гарчиг,
- 16 дугаар зүйлийн 16.1, 16.3,
- 17 дугаар зүйлийн 17.1, 17.5-17.7 дахь хэсэг,
- 18 дугаар зүйлийн гарчиг,
- 18 дугаар зүйлийн 18.4, 18.5 дахь хэсэг,
- 19 дүгээр зүйлийн гарчиг,
- 19 дүгээр зүйлийн 19.1 дэх хэсэг, 19.1.2, 19.1.3 дахь заалт, 19.2, 19.3, 19.6 дахь хэсэг,
- 20 дугаар зүйлийн гарчиг,
- 21 дүгээр зүйлийн гарчиг,
- 21 дүгээр зүйлийн 21.1-21.3 дахь хэсэг, 21.5, 21.6 дахь хэсэг,
- 23 дугаар зүйлийн гарчиг,
- 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг,
- 24 дүгээр зүйлийн 24.1.2, 24.1.4 дэх заалт,
- 25 дугаар зүйлийн гарчиг,
- 25 дугаар зүйлийн 25.1, 25.2 дахь хэсэг,
- 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг, 27.1.1, 27.1.2, 27.1.3, 25.1.5 дахь заалт,
- 28 дугаар зүйлийн гарчиг,
- 28 дугаар зүйлийн 28.1.1-28.1.4 дэх заалт, 28.1.7, 28.1.8 дахь заалт,
- 30 дугаар зүйлийн гарчиг,
- 30 дугаар зүйлийн 30.1-30.6 дахь хэсэг,
- 31 дүгээр зүйлийн гарчиг,
- 31 дүгээр зүйлийн 31.1, 31.2 дахь хэсэг,
- 32 дугаар зүйлийн гарчиг,

- 32 дугаар зүйлийн 32.1, 32.2 дахь хэсэг,
- 33 дугаар зүйлийн гарчиг,
- 33 дугаар зүйлийн 33.1-33.2 дахь хэсэг,
- 34 дүгээр зүйлийн гарчиг,
- 34 дүгээр зүйлийн 34.1, 34.2, 34.3 дахь хэсэг,
- 35 дугаар зүйлийн гарчиг,
- 36 дугаар зүйлийн 35.1-35.3 дахь хэсэг,
- 36 дугаар зүйлийн гарчиг,
- 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг,
- 37 дугаар зүйлийн гарчиг,
- 37 зүйлийн 37.1 дэх хэсэг,
- 38 дугаар зүйлийн гарчиг,
- 38 дугаар зүйлийн 38.1-38.3 дахь хэсэг,
- 39 дүгээр зүйлийн гарчиг,
- 39 дүгээр зүйлийн 39.1, 39.2, 39.7 дахь хэсгийн "...болон албаны" гэснийг,
- 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсэг

Дээр дурдсан өөрчлөлт нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 50 хувиас илүү заалтыг хөндөж байгаа тул Монгол Улсын Засгийн газраас өгсөн саналыг хүлээн авч хуульд нэмэлт өөрчлөлт, оруулах хуулийн төсөл хэлбэртэй байсныг шинэ найруулга хэлбэрт оруулан өөрчилсөн болно.

Төрийн нууцын тухай хуулийн төсөлд хууль зөрчсөн үйлдэл, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдээлэл, хүний үндсэн эрх, эрх чөлөөг зөрчсөн баримтыг нууцын аль ч зэрэглэлд хамааруулахгүй байхаар мөн тусгасан болно. Үүнээс гадна хууль гаргахгүйгээр аливаа мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг төрийн нууцад хамааруулахыг хориглохоор төсөлд шинээр тус тус тусгасан.

Төрийн нууцад авах харилцааг шинэчилж байгаатай холбогдуулан төрийн нууцад хамааруулахаар Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн мэдээллийг нууцн зэрэглэлтэйд тооцож хамгаалалтад авахаар төсөлд тусгасан.

Мөн түүнчлэн төсөлд “онц чухал нууц, маш нууц” зэрэглэлээс гадна нууц гэсэн зэрэглэл нэмж нийт гурван шаталсан нууцын зэрэглэлтэй байхаар төсөлд тусгасан.

Нууц зэрэглэл нэмэхээр тусгасантай холбогдуулан Задруулах, үрэгдүүлэх тохиолдолд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, үндэсний ашиг сонирхолд шууд аюул учруулахгүй боловч төрийн ашиг сонирхол, үндэсний аюулгүй байдлын тодорхой чиглэлд сөрөг нөлөө үзүүлэх, батлан хамгаалах, нийтийн аюулгүй байдал, гадаад бодлогын хэрэгжилтэд бодит хохирол учруулах мэдээллийг “нууц” зэрэглэлд хамааруулахаар төсөлд мөн тусгав.

Төрийн нууцын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан эрх зүйн уялдаа холбоог хангах, хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн зөрчил, давхардлыг арилгах, шинэчилсэн зохицуулалтад

нийцүүлэн холбогдох хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагын хүрээнд дагалдах хуулийн төслүүдийг боловсруулсан болно. Эдгээр төслөөр төрийн нууцын эрх зүйн шинэ зохицуулалтыг хэрэгжүүлэх шилжилтийн үеийн журмыг тогтоох, өмнө мөрдөж байсан Төрийн болон албаны нууцын тухай хуулийг хүчингүй болгох, мөн бусад хууль тогтоомж дахь нэр томъёо, зохицуулалтыг шинэчилсэн найруулгатай нийцүүлэх асуудлыг тусгасан.

Юуны өмнө, Төрийн нууцын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслөөр шинэ хууль хэрэгжих шилжилтийн зохицуулалтыг тодорхой болгосон. Тухайлбал, Засгийн газар шинэчилсэн найруулга хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 6 сарын дотор Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх, шинэ жагсаалт батлагдах хүртэл одоо мөрдөж байгаа жагсаалтыг хүчинтэйд тооцох, мөн шинэ жагсаалт батлагдсанаар өмнөх хуулийн дагуу албаны нууцад хамааруулж байсан мэдээллийг ил болсонд тооцох зохицуулалтыг тусгасан. Мөн шинэ хуульд заасан дүрэм, журам батлагдах хүртэл өмнө мөрдөж байсан дүрэм, журмыг хүчин төгөлдөр мөрдөхөөр зохицуулсан.

Мөн Төрийн болон албаны нууцын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслөөр 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдөр батлагдсан Төрийн болон албаны нууцын тухай хуулийг хүчингүй болгохоор боловсруулсан. Ингэснээр төрийн нууцын эрх зүйн зохицуулалтыг шинэчилсэн найруулгын хүрээнд нэг мөр хэрэгжүүлэх эрх зүйн үндэс бүрдэх юм.

Үүний зэрэгцээ Архив, албан хэрэг хөтлөлт, Гүйцэтгэх ажил, Захиргааны ерөнхий хууль, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Кибер аюулгүй байдал, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай, Өмгөөллийн тухай, Тагнуулын байгууллагын тухай, Төрийн албаны тухай, Төрийн аудитын тухай, Цагдаагийн албаны тухай, Шүүх шинжилгээний тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай болон бусад холбогдох хуульд орсон “болон албаны” гэсэн томъёоллыг хасах өөрчлөлтүүдийг боловсруулсан. Энэ нь шинэчилсэн найруулгын үзэл баримтлалын дагуу “албаны нууц” гэсэн өмнөх ангиллыг хуучин хэлбэрээр хадгалахгүй, төрийн нууцтай холбоотой зохицуулалтыг хууль тогтоомжийн түвшинд нэг мөр болгох зорилготой.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр төрийн нууцад хамаарах эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны онцлогийг илүү тодорхой болгохыг зорьсон. Энэ хүрээнд “шүүх хуралдаан ажиглагч” гэсэн ойлголтыг шинээр тодорхойлж, нэгтгэсэн эрүүгийн хэргийн зарим нь төрийн нууцад хамаарах тохиолдолд төрийн нууцтай холбоотой хэсгийг хаалттай, бусад хэсгийг нээлттэй явуулах зохицуулалтыг тусгасан. Түүнчлэн Төрийн нууцын тухай хуульд заасан шаардлага хангасан иргэнийг төрийн нууцад хамаарах хэрэг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд ажиглагчаар оролцуулах, мөн төрийн нууцтай танилцах эрх олгогдсон этгээдийг тодорхой нөхцөлөөр ажиглагчаар оролцох боломжийг бүрдүүлсэн. Үүнээс гадна холбогдох хэд хэдэн заалтаас “болон албаны” гэснийг хасаж, 34.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийг хүчингүй болгохоор тусгасан.

Мөн Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулсан. Уг төслөөр Эрүүгийн хуулийн 19.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан төрийн нууцтай холбоотой гэмт хэргийн бүрэлдэхүүнийг илүү тодорхой болгох үүднээс “цуглуулсан, хадгалсан” гэснийг “эрх бүхий албан тушаалтан хуульд заасан үндэслэл, журмыг зөрчиж цуглуулсан, дамжуулсан, хадгалсан” гэж өөрчлөхөөр тусгасан. Ингэснээр эрүүгийн хариуцлага хүлээлгэх хүрээ, нөхцөлийг илүү тодорхой болгож, хуулийн хэрэглээний зөрүүг багасгах ач холбогдолтой. Түүнчлэн төрийн нууцыг хадгалах, хамгаалах хуулиар хүлээсэн үүрэггүй хүн төрийн нууцыг олж авсан нь гэмт хэрэгт хамтран оролцох шинжгүй бол эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх агуулгатай тайлбарыг 19.11 дүгээр зүйлд нэмж тусгасан.

Иймд дээрх дагалдах хуулийн төслүүдийг боловсруулснаар Төрийн нууцын тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийг дагаж мөрдөх эрх зүйн орчин бүрдэх, холбогдох бусад хууль тогтоомжийн нэр томьёо, зохицуулалтыг шинэчилсэн найруулгатай нийцүүлэх, хууль хэрэглээний зөрчил, хийдлийг арилгах, төрийн нууцтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг илүү тодорхой, ойлгомжтой болгох нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

ХУУЛЬ САНААЧЛАГЧ